



ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн цахим тусламж үйлчилгээ үзүүлэх журам батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалт, Төвийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эх, нярай, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад цахим тусламж үйлчилгээг тогтмол, үр дүнтэй ашиглаж, орон нутгийн эмч, мэргэжилтнүүдийг эмнэлзүйн шинэ удирдамж, нотолгоо, мэдээллээр хангаж багаар ажиллах, эмнэлзүйн тулгамдсан асуудалд шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх зорилгоор 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн цахим тусламж үйлчилгээ үзүүлэх журмыг нэгдүгээр, цахим тусламж үйлчилгээ үзүүлэх зөвлөх эмч нарын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Цахим тусламж үйлчилгээ үзүүлэх журмыг зөвлөх эмч нарт танилцуулж, үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, зөвлөх эмчийн цахим зөвлөгөө өгсөн тайланг үндэслэн цалин хөлс олгох цагийн тооцоог гаргаж, журмыг хэрэгжүүлэн ажиллахыг Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал /Г.Баттулга/-д үүрэг болгосугай.

3. Эмнэлзүй эрхэлсэн дэд захирлын баталсан цагийн тооцоог үндэслэн журмын дагуу цалин хөлс тооцон олгохыг Санхүү нягтлан бодох бүртгэлийн албаны Ахлах нягтлан бодогч /М.Жавхлан/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдлийн албаны дарга /А.Оюунчимэг/, Хүний нөөцийн албаны дарга /Б.Мөнхшүр/ нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



Ж.Отгонбаатар

Ж.ОТГОНБААТАР

1606060195

Захирлын.....оны.....сарын.....өдрийн
А/Б... дугаар тушаалын.....хавсралт

**ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЭХ БАРИХ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМНЭЛГИЙН ЦАХИМ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Зорилго:

Эх, нярай, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад цахим тусламж үйлчилгээг тогтмол, үр дүнтэй ашиглаж орон нутгийн эмч, мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, багаар ажиллах, эмнэлзүйн тулгамдсан асуудалд шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх

1.2. Зорилт:

1. Эмнэлзүйн шинэ удирдамж, нотолгоо, мэдээллээр орон нутгийн эмч нарыг мэдээллээр хангах
2. Цахим хэрэгсэл ашиглан эмнэлзүйн зөвлөгөөг цаг хугацаа алдахгүй өгөх
3. Үзүүлж буй тусламж үйлчилгээг олон талын эх сурвалжид үндэслэн бататгаж, эргэлзээтэй асуудлыг шийдвэрлэх
4. Өгсөн зөвлөгөөний дагуу шаардлагатай тусламжийг үзүүлсэн эсэхийг хэлэлцэх, эргэх хяналтын тогтолцоог сайжруулах
5. Эмч мэргэжилтний хоорондын харилцаа, ёс зүйн хэм хэмжээг бэхжүүлэх
6. Яаралтай, тасралгүй, хуваарьт аль ч хэлбэрийн цахим тусламж үйлчилгээг нэг эх сурвалжаар өгч хэвших

1.3. Хамрах хүрээ:

Энэхүү журам нь төв эмнэлгийн эх барих, эмэгтэйчүүдийн тасаг нэгж болон хөдөө, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад цахимаар зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хамаарна.

Хоёр. Нэр томъёо:

- 2.1. “Цахим зөвлөгөө” гэж мэдээлэл, холбооны технологи ашиглан зайнаас мэргэжлийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг хэлнэ.
- 2.2. “Зөвлөх эмч” гэж тухайн чиглэлээр мэргэшсэн, цахим зөвлөгөө өгөхөөр томилогдсон эмчийг хэлнэ.
- 2.3. “Хүсэлт гаргагч байгууллага” гэж орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг хэлнэ.

Гурав. Цахим тусламж үйлчилгээний төрөл:

- 3.1. Яаралтай зөвлөгөө
- 3.2. Төлөвлөгөөт зөвлөгөө
- 3.3. Онош тодруулах зөвлөгөө
- 3.4. Мэргэжил арга зүйн сургалт, хэлэлцүүлэг
- 3.5. Кейс хэлэлцүүлэг

Дөрөв. Цахим тусламж үйлчилгээний зохион байгуулалт:

1. 21 аймагт томилогдсон зөвлөх эмч нар батлагдсан хуваарийн дагуу цахим тусламж үйлчилгээ үзүүлнэ.
2. Нэг аймагт нэг долоо хоногийн нэг өдрийг сонгон хуваарьт цахим үзлэг хийнэ.
3. Хуваарьт үзлэгийг цахим тойрон үзлэг, онолын мэдээлэл, тохиолдлын хэлэлцүүлэг хэлбэрээр эсвэл тухайн нөхцлөөс шалтгаалан хослуулан хийж болно.
4. Цахим тойрон үзлэгийг зөвлөх эмч ганцаарчилсан эсвэл багаар хийнэ.
5. Цахим үзлэг хийхэд оролцох багийн гишүүдийг онолын мэдээлэл өгөх, сэдвийг тухайн бүсэд томилогдсон зөвлөх эмч хэрэгцээнд нийцүүлэн тухай бүр гаргана.
6. Тойрон үзлэгийн үргэлжлэх хугацаа 2 цагаас ихгүй байна.
7. Цахим мэдээллийг олон сувгийг ашиглана. Телемедицин, телеграм, Zoom, Google meet гэх мэт. Аюулгүй байдал хангагдсан нөхцөлд өвчтөний мэдээллийг дамжуулна.
8. Хөдөө орон нутгаас цахим үзлэгээр шилжүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд цахим үзлэгийн хуудас, тухайн аймгийг хариуцсан зөвлөх эмчийн шийдвэрийн хамт шилжүүлнэ.

Тав. Зөвлөх эмчийн эрх, үүрэг:

5.1. Зөвлөх эмчийн эрх:

- 5.1.1. Шаардлагатай эмнэлзүйн мэдээлэл шаардах
- 5.1.2. Онош, эмчилгээний зөвлөмж өгөх
- 5.1.3. Кейсийг шатлал ахиулах санал гаргах

5.2. Зөвлөх эмчийг үүрэг:

- 5.2.1. Цахим зөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу өгөх
- 5.2.2. Нууцлалыг чанд хадгалах
- 5.2.3. Баримтад тулгуурласан зөвлөмж өгөх
- 5.2.4. Зөвлөгөөний бүртгэл, тайланг сар бүр гаргах
- 5.2.5. Мэргэжлийн ёс зүйг мөрдөж ажиллах

Зургаа. Хүрэх үр дүн:

- 6.1. Зайн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөөний цар хүрээ өргөжиж, үйл ажиллагаа тогтмолжино.
- 6.2. Орон нутагт ажиллаж байгаа эмч, мэргэжилтний онолын ба эмнэлзүйн мэдлэг, ур чадвар сайжирч нотолгоонд суурилсан тусламжийг үзүүлнэ.
- 6.3. Эмч нарт үзлэг, оношилгоо, эмчилгээний арга барил, туршлага хуримтлагдана.
- 6.4. Зөвлөх эмч нар багаар хамтарч ажиллах туршлага илүү хуримтлагдана.
- 6.5. Бүс, орон нутгийн эмч нар яаралтай, тасралтгүй, хуваарьт аль ч хэлбэрийн цахим тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх, тухайн аймаг орон нутгаас үйлчлүүлэгчийг шилжүүлэх үед холбогдох хүн тодорхой болно.
- 6.6. Хуваарьт үзлэгт цахим тойрон үзлэгийг нэвтрүүлэн ажиллана.

- 6.7. Зөвлөх эмч өөрийн томилогдсон бүс нутгаас ирж буй дуудлага, өвчлөл эндэгдлийн бүтцэд үндэслэн хуваарьт үзлэгээр олгох онолын мэдээллийг сонгосноор эрэлтэд нийцсэн зөвлөгөөг өгөх боломж бүрдэнэ.
- 6.8. Цахим тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал дээшилж үйл ажиллагаа тогтмолжино.
- 6.9. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж сайжирна.
- 6.10. Эмчийн ёс зүй, харилцаа хандлага сайжирна.

Долоо. Санхүүжилт:

- 7.1. Зөвлөх эмчийн зөвлөгөө өгч ажилласан нэг цагийн хөлс 60.000 төгрөг байна.
- 7.2. Ажлын хөлсийг гүйцэтгэлд үндэслэн олгох ба ажлын тайлан, илүү цагийн тооцоог Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал хянаж баталгаажуулна.
- 7.3. Эмнэлзүй эрхэлсэн дэд захирлын баталсан цагийн тооцооны дагуу зөвлөх эмчийн цалин хөлсийг тооцон холбогдох хууль журмын дагуу татвар шимтгэлийг хасаж олгоно.

Найм. Хяналт үнэлгээ:

- 8.1. Цахим үзлэг болон зөвлөгөөг тасгийн, алсын дуудлагын болон төвийн статистик бүртгэлд албан ёсоор бүртгэж, тогтмол мэдээлж байна.
- 8.2. Цахим зөвлөгөө өгсөн тохиолдол бүрийг баримтжуулж, зөвлөгөө авсан үйлчлүүлэгчийн түүхэнд хавсаргасан байна.
- 8.3. Жил бүр үнэлгээ хийж сайжруулна.

Захирлын 2026 оны 02 сарын 07
 А/38 дугаар тушаалын 28 хавсралт

**Эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмчээр ажиллах эмч нарын нэрс,
 зөвлөгөө өгөх хуваарь**

№	Аймгийн нэр	Хариуцах зөвлөх эмч	Аймгийн зөвлөх эмч
1.	Архангай	Д.Дондогдорж	Ч.Ариунжаргал
2.	Баян-Өлгий	М.Энхжаргал	Н.Ержан
3.	Баянхонгор	Ж.Отгонбаатар	Б.Мөнхжаргал
4.	Булган	Ж.Сарантунгалаг	Б.Цогтгэрэл
5.	Говь-Алтай	Д.Дондогдорж	А.Сувдмаа
6.	Говьсүмбэр	Г.Баттулга	О.Оюун
7.	Дархан-Уул	Я.Хишигсүрэн	Ц.Солонго
8.	Дорноговь	Ж.Энхтуяа	Байхгүй
9.	Дорнод	С.Хишгээ	Сарангэрэл
10.	Дундговь	Б.Алтанцэцэг	Ж.Өлзийбаяр
11.	Завхан	Г.Баттулга	Д.Уранбилэг
12.	Орхон	Ж.Сарантунгалаг	Л.Ганболд
13.	Өвөрхангай	Д.Дондогдорж	Баярсайхан
14.	Өмнөговь	Б.Алтанцэцэг	Б.Мөнхбат
15.	Сүхбаатар	Ж.Энхтуяа	Р.Сувдаа
16.	Сэлэнгэ	Ж.Энхтуяа	Байхгүй
17.	Төв	Ж.Отгонбаатар	С.Төгсбаяр
18.	Увс	Г.Баттулга	Н.Шинэхүү
19.	Ховд	М.Энхжаргал	Ц.Нарангэрэл, Даваабал
20.	Хөвсгөл	Я.Хишигсүрэн	П.Отгонбаяр
21.	Хэнтий	С.Хишгээ	Кульжан

Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн зөвлөх эмчээр ажиллах эмч нарын нэрс

1. С.Амармандах
2. Б.Лхагвасүрэн
3. Х.Урангуа
4. Ц.Эрдэнэбаяр
5. Б.Мөнгөн